



Цахим хичээл (№20)

Дөрөвдүгээр сарын 27-ны өдөр 20 дахь удаагийн цахим хичээлийг хийж төслийн фэйсбүүк хуудсанд байршуулав. Энэ удаад маркетингийн мэргэжилтэн хатагтай Это Козуй хичээлийг удирдсан ба бүтээгдэхүүний дизайныг бий болгох үед **ӨНГӨНИЙ ЗОХИЦОЛ** шийдвэрлэх ач холбогдолтой байдаг тухай лекц уншлаа.

Өмнөх онлайн хичээлийг үзсэн хүмүүсээс ирүүлсэн саналд үндэслэн энэ удаагийн хичээлийн сэдвийг сонгосон болно. Бид цаашдын цахим хичээлийн агуулгад та бүхний санал хүсэлтийг тусгах тул бидэнтэй үргэлжлүүлэн хамтран ажиллахыг хүсэж байна.



ТӨСЛИЙН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА ③



Маркетингийн мэргэжилтэн Это Козуэ

“Та маш их хичээч хийсэн учраас танай зөгийн балыг худалдан авмаар байна” гэж хэлэх үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжийн тухай цахим хичээлүүдээр хүргэхийг хүсэж байна. Таны санал сэтгэгдлийг тэсэн яадан хүлээж байна!



Орчуулагч А.Хоролсүрэн

Миний хувьд энэ төслийн багт орж ажиллаж байгаадаа баяртай байдаг. Мөн зөгийчин хүмүүс маш хөдөлмөрч, цэцэг дэлгэрсэн байгаль шигээ сайхан сэтгэлтэй байдаг нь надад урам зориг төрүүлдэг.

ЗАА эрхлэгчидтэй хамтран цахим судалгаа хэрэгжүүлж байна !


Төслийн багаас Монголын ЗАА-н бодит байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор цахим санал асуулгыг хэрэгжүүлж байна. Эхний судалгаа нь өвөлжилт түүний дараах нөхцөл байдалд чиглэсэн ба нийт 44 зөгийчин оролцож хариулт ирүүлсэн. Үүнд өвөлжилт 12%, өвөлжилтийн үед болон өвөлжсөн даруй дахь эхийн хорогдол 5% зэрэг дүнгүүд харагдаж байна. Судалгааны дүн мэдээллийг төслийн фэйсбүүк хуудсанд байршуулав.



Мөн 5-р сарын 18 –ны өдрөөс эхлэн варроа хачигтай тэмцэж буй байдлыг тодорхойлох зорилгоор хоёр дахь санал асуулгыг хэрэгжүүлж эхлээд байна. Зөгийчид та бүхнийг оролцохыг уриалж байна.

Холбогдох талуудтай хамтран ажиллах

Бид холбогдох байгууллагуудтай цахим уулзалт болон бусад аргаар тогтмол хугацаанд мэдээлэл солилцдог. Дөрөвдүгээр сарын эхэнд ЗАА-д мөрдөх хяналтын хуудсын шинэчлэн боловсруулах чиглэлээр МХЕГ-ын мэргэжилтнүүдтэй уулзалт хийлээ. Мөн дөрөвдүгээр сарын сүүлээр төслийн үйл ажиллагааны явцын тухай мэдээллийг төсөл хариуцагч тал болох ХХААХҮЯ-ны МААБХЗГ-тай солилцлоо. Цаашид бусад холбогдох талуудтай үр дүнтэй хамтран ажиллах болно.



Төслийн Facebook :

www.facebook.com/BeeDep-MONGOL-2-107843977265085/?modal=admin_todo_tour

Онлайн семинарыг хүргэж байна !

